



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/358

Хэрлэн сум

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.11, Газрын тухай хуулийн 48¹ дүгээр зүйлийн 48¹.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл"-ийн хүрээнд аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшлийн газарт дулаан дамжуулах төвийг байрлуулахаар зураг төсөлд тусгагдсаны дагуу Газрын тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг үндэслэн шийдвэр гаргах, газрын цахим мэдээллийн санд оруулж баталгаажуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Л.Батсайхан	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Г.Лхагвабаатар	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	Э.Мөнх-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
	Б.Дарханбаатар	Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга,
	Т.Жанчив	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч
	Б.Сүнгээ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
	Ш.Ариунболор	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн

2.

Т.Наранбаяр	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн
М.Шүрэнцэцэг	Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч
Б.Одгэрэл	Хэрлэн сумын Газрын даамал
Д.Эрхэмбаяр	Хэнтий-Ус ХХК-ийн Ерөнхий инженер

2. Дулааны станцын дулаан дамжуулах төвийн байршлыг тогтоох асуудлыг холбогдох хууль, дүрэм, журам болон батлагдсан ажлын зургийн дагуу зохион байгуулан баталгаажуулж дүнг танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ